# УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ТӨВИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2023-12-13

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ ТУСГАГДСАН ЗОРИЛТ** | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт:1.1 Ажиллагсад болон үйлчлүүлэгчдэд ээлтэй орчинг бүрдүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжруулж ажиллана** | | | | | | | |
| 1.1.1 | Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2021-2025)<br><br>2.2.2, 2.2.3 | БӨХ | Эрүүл мэндийн салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих зорилтот хөтөлбөр ("Эрүүл идэвхтэй амьдрал") зэрэг арга хэмжээнүүдийг өөрийн тусламж үйлчилгээнд зохицуулан хэрэгжүүлж ажиллана. | 80% | 85% | Эрүүл мэндийн яамнаас "Энэ жил эрүүл жиндээ" аяныг эхлүүлж байгаатай холбогдуулан байгууллагын хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 3 сарын хугацаатай, 7 дугаар сарын 01-ээс 6 сарын хугацаатай аяны удирдамж боловсруулан батлуулж хэрэгжүүлэн ажиллаж 22 ажилтан хамруулсан.<br><br>Үүнд 3 сарын байдлаар:<br>➢ Хэвийн жинтэй 7 ажилтан<br>➢ Илүүдэл жинтэй 8 ажилтан<br>➢ Таргалалтай 5 ажилтан<br>➢ Тураалтай 1 ажилтан байна.<br>Ажилчдын биеийн жинг 7 сард үзэхэд биеийн жингийн үзүүлэлт өмнөх үзүүлэлтээс 20%-иар буурсан ахиц гарсан байна.<br><br>3.Баруун бүсийн олимпид бэлтгэх төвийн багш Г.Түвшинбаттай 1 сарын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөлмөрийн гэрээ байгуулан нийт ажилчдад волейболын анхан шатны сургалтыг авсан.<br>Баруун бүсийн олимпт бэлтгэх төвтэй хамтран 7 хоног бүрийн 5 дахь өдрийн 18.00 цагаас 2 цаг гар бөмбөг тоглодог.<br>Бүжгийн багшаар их эмч Б.Мөнх-Итгэл, ахлах сувилагч Э.Сарангоо нар үдийн цайнаар 10 минутын бүжиг заалгадаг.<br>Өглөө бүр сургагч багш Оюунтай гэрээ хийж үйлчлүүлэгч нарт хоол, дасгал хөдөлгөөн, бясалгал, идээ ундаа, явдал мөрийн сургалтыг 10 минут, дасгал хөдөлгөөнийг 20 минутад хийж хэвшсэнээр эрүүл идэвхтэй амьдрах зан үйлд бүх үйлчлүүлэгчдийг хамруулж байна.<br><br>Хүн амын зонхилон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлэх иргэдэд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих хамгаалах, сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх зорилгоор хий өвчнөөс урьдчилан сэргийлье уриан дор 2023 оны 07 сараас 12 сарын 31-ийг хүртэл иргэдэд явдал мөрийн сургалт хийх, санамж, брошур тараан ажиллаж байна.<br><br>Одоогоор 350 хүнд сургалт хийж 102 хүнд брошураар үйлчилсэн. | |
| | | БӨХ | Оношилгоо эмчилгээнд шинэ технологи нэвтрүүлэн мөрдөж ажиллана. | 0 | 50% | Шинээр гуаша эмчилгээг эмчилгээ үйлчилгээндээ нэвтрүүлэн ажиллаж байна.<br><br>Эмчилгээний хаш чулуу, зэс, оливийн тос, гүнжидын тосыг ашиглаж нэг удаадаа 20 минутаар 3-5 удаа | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Dachangshu BL25, Xiaochangshu BL25. Tianshu ST25, Daheng SP15, Fujie SP14 гэх мэт цэгүүдээр нүх сүвүүдийн хоорондох холбоог онгойлгож суваг хэрдсийн үйл ажиллагааг идэвхжүүлээд эрчим хүч цус зогсонгошлыг арилгах, цул сав эрхтний үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 215 хүнд хийсэн байна. | |
| | | БӨХ | Цагаан судлын өвчний үед хийх хөдөлгөөн засал эмчилгээг өргөжүүлнэ. | 3 | 6 | Хөдөлмөр болон хөдөлгөөн засалч сувилагчийн орон тоо 1-ээр нэмэгдэж хөдөлмөр заслын өрөөг шинээр гарган тохижуулсан.<br><br>Хөдөлмөр, хөдөлгөөн засалч сувилагчтай болсноор саа саажилттай, хэл ярианы эмгэгтэй 47 хүнд хөдөлмөр засал эмчилгээг 14 нэр төрлийн багаж тоног төхөөрөмж бүрдүүлэн ашиглаж үр дүнг тооцон ажилласан.Үүнд:<br><br>✓ Хүзүүний булчин суллах дасгал 10<br>✓ Нурууны булчин суллах дасгал 13<br>✓ Түнхний үеэр нугалах, тэнийлгэх дасгал 5<br>✓ Өвдөгний үеэр нугалж тэнийлгэх дасгал 5<br>✓ Мөрний үеэр нугалж тэнилйгэх дасгал 4<br>✓ Тохойны үеэр нугалж тэнийлгэх дасгал 5<br>✓ Гарын нийлмэл үйл ажиллагааг сайжруулах дасгал 5 хүнд тус тус хийж үйлчилсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.4 | | БӨХ | Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг баталж, дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргаж ажиллана. | 8 | 11 | 1.Сувилахуйн тусламж үйлчилгээний стандартуудыг төрөлжүүлэн 4 ш гарын авлага бэлтгэн ажиллалаа.<br><br>Үүнд:<br><br>➢ Сүүн бариа, халуун тосон бариа, цэгэн бариа, даран бариа, хэсэг газрын бариа тус бүрийн онцлог, ижил ба ялгаатай талууд.<br>➢ Шавар, парафин эмчилгээ үйлчилгээний онцлог шинж тэмдгүүд<br>➢ Физик эмчилгээний багаж тоног төхөөрөмжүүдийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа<br>➢ Цагаан судлын өвчний үед хийх хөдөлгөөн засал ба хөдөлмөр засал эмчилгээ<br><br>2. Уламжлалт анагаах ухааны төвөөс нэг жилийн хугацаанд зарласан “Ажилтан бүр судлаач” аяны хүрээнд<br><br>➢ Сувилагч Г.Ариунтуяа “Голын хий өвчнийг бариа заслаар эмчлэн дүнг тооцох нь”<br>➢ Эм найруулагч Б.Бямбажав “Монгол эмийн хадгалалт хамгаалалт түүнд тавих хяналт үр дүнг тооцох”<br>➢ Сувилагч Д.Бүжинлхам “Харандаан төөнө заслаар хаван буулгах нь”<br>➢ Сувилагч С.Мядагмаа “Мартах хам шинж бүхий өвчтөн ба хөдөлмөр засал эмчилгээ”<br>➢ Сувилагч Б.Нямдаваа “Ясны ургалтад шавар болон физик | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмчилгээ хийж харьцуулан судалж үр дүнг тооцох нь”<br>➢ Сувилагч Юнрэндорж “Тархи дорголтыг бариа заслын арга болон эмийн эмчилгээтэй харьцуулан судлах нь” зэрэг сэдвүүдээр эрдэм шинжилгээ судалгааны ажил хийхээр төлөвлөн гүйцэтгэл 30%- тай явж байна. | |
| 1.1.5 | | БӨХ | ЭМТҮЧАБ-ын багтай хамтран сувилахуйн эмнэл зүйн хэлэлцүүлэг хийнэ. | 2 | 4 | Сувилахуйн баг нь ЭМТҮЧАБ-ын багтай хамтран цахим программд өвчтөний түүхэнд хийгдсэн эмчилгээнүүд болон хяналтын хуудас, эмчилгээний хуудсыг хэрхэн зөв бөглөх талаар эмнэл зүйн хэлэлцүүлгийг хийж дутагдалтай байгаа сэдвүүдээр дүн бүртгэгч Б.Ариунжаргал 4 цагийн сургалтыг 7 сувилагчид явуулж үр дүнг тооцон ажиллаж байна.<br><br>8 дугаар сард Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн уламжлалтын тасгийн эмч сувилагч нартай “Уламжлалт анагаах ухааны өнөөгийн байдал, бидний оролцоо” сэдэвт хэлэлцүүлгийг хийж ололттой тал ба тулгамдаж буй асуудлуудыг 5 чиглэлээр тодорхойлж дээд шатны байгууллагад хүргүүлсэн.<br><br>Зарим нэг бариа заслыг багаж тоног төхөөрөмжөөр орлуулан гүйцэтгэх боломжтойг судлан 2024 оны төлөвлөгөөнд тусгахаар шийдвэрлэсэн.<br><br>2 дахь өдрөө Увс аймгийн уламжлалт анагаах ухааны эмч мэргэжилтнүүдтэй нөхөрсөг гар бөмбөгийн тэмцээн зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулж амжилттай оролцсон.<br><br>9 сарын 11-нд ЭМТҮЧАБ-ын багтай хамтран сувилахуйн эмнэл зүйн хэлэлцүүлгийг “Харилцааны бэрхшээлтэй өвчнийг таних арга” сэдвээр 4 цагийн сургалтыг сувилагч нарт явуулсан.<br><br>Говь -Алтай аймгийн АШУҮИС-ийн уламжлалтын сувилахуйн ангийн 2 оюутанд чанарын багтай хамтран дадлагын ажлыг амжилттай зохион байгуулсан. | |
| 1.1.6 | | БӨХ | Шавар эмчилгээг лазер аппараттай хослуулан ясны ургалтад нөлөөлөх судалгааг хийж үр дүнг тооцон ажиллана. | 0 | 1 | Их эмч Э.Сайханжаргал, сувилагч Б.Нямдаваа нар хамтран эмчлүүлэгчдын дунд ”Шавар эмчилгээг лазер аппараттай хослуулан ясны ургалтад нөлөөлөх нь” судалгаа хийж үр дүнг тооцон ажиллаж байна. Одоогийн байдлаар 10 хүнд судалгаа хийгдэж 7 хүн үр дүнд хүрсэн үзүүлттэй байна.<br><br>Олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан “Сувилагчийн эрхийг хамгаалах” жилийн хүрээнд “Бидний сувилагч-Бидний ирээдүй” уриан дор 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан эрдэм шинжилгээний бага хуралд Уламжлалтын их эмч Д.Өлзийбаяр, Э.Сайханжаргал нар удирдаж сувилагч Х.Пүрэвхүүгийн “Тулай өвчний үед сэндэнтэй ороолт буюу шавар эмчилгээ хоёрын үр дүнг харьцуулсан судалгаа” сэдвээр илтгэл тавьж III байр эзэлсэн.<br><br>Говь-Алтай аймагт зохион байгуулагдсан баруун бүсийн илтгэлийн уралдаанд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тэргүүн байр эзэлж notebook-ээр шагнагдсан.<br><br>Мөн баруун бүсийн уламжлалт анагаах ухааны анхдугаар чуулган Увс аймагт зохион байгуулагдаж сувилагч Пүрэвхүү “Тулай өвчний үед сэндэнтэй ороолт буюу шавар эмчилгээ хоёрын үр дүнг харьцуулсан судалгаа” сэдэвт илтгэлээрээ хоёрдугаар байр эзэлсэн. | |
| 1.1.7 | ЗГ-ын Үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024)<br><br>1.1.3.1, 1.1.3.3 | БӨХ | Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ | 70% | 80% | Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэн ажиллахад эмийн нөөцөд 97 нэр төрлийн 3100.0 мянган төгрөгийн эм тариа, хувцас хэрэгсэл байна.<br><br>2023 оны 6 дугаар сарын 05-ны өдөр Их-Уул, Цагаанхайрхан сумаас ирж эмчлүүлж буй гэр бүлийн 4 хүнд зовиур илэрч шинжилгээ хийхэд коронавирусын халдвартай нь батлагдаж тусгаарлан эмчилгээ хийж СэБоЦэ ХХК хамтран ариутгал цэвэрлэгээ хийж, халдварын голомтыг таслан ажиллаж байна. | 100 |
| 1.1.8 | Завхан аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл | БӨХ | Тусламж үйлчилгээний төрөл, кабинетүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих шалгуур, хяналтын хуудсанд хяналт тавьж хэрэгжилтийг хангаж ажиллана. | 5 | 8 | Тусламж үйлчилгээний төрөл, кабинетүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих шалгуур, хяналтын хуудсыг чанарын баг 10, сувилахуйн баг 17, халдвар хамгааллын баг 11 үзүүлэлтээр тус тус хяналт тавьж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.9 | “Чадварлаг эмч” арга хэмжээний хүрээнд | БӨХ | Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор цалин хөлс нэмэгдүүлэх, дархлааг дэмжих, спортын цогц арга хэмжээг авч ажиллана. | 18 | 22 | 1.Засгийн газрын 488, 489 дүгээр тогтоолын дагуу байгууллагын удирдлагын зөвлөлийн шийдвэрээр нийт ажилчдын цалинг 2023 оны 01 дүгээр сарын 2-ны өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл бүх ажилчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлэн ажилласан.<br><br>2.Хөдөлмөрийн дотоод журмын 13.1.6 дэх заалтын дагуу ажилчдын эрүүл мэндийн дэмжих зорилгоор 2023 оны 2 дугаар сард 18 ажилтанг өөрийн эмнэлэгт хэвтүүлэн эмчилж өөрийн орлого болох 10 хувийн 1437750 төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн.<br>Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор I, II, III улирлын үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл 21 хүнд 37469426 төгрөгийг олгосон.<br><br>Эрүүл мэндийн яамны шагнал Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтнаар физик эмчилгээний сувилагч Б.Нямдаваа, Хүндэт Жуух бичгээр тогооч А.Хажидмаа нар тус тус шагнагдсан.<br>Эрүүл мэндийн салбарын “Оны шилдэг санхүүгийн ажилтан”-аар нярав Б.Норовсамбуу шалгарсан.<br>Байгууллагын “Оны шилдэг ажилтан”-аар сувилагч Д.Бүжинлхам шалгарч байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу 1 сарын үндсэн цалингаар шагнаж урамшуулсан.<br>ЭМЯ-ны шагналаар шагнуулахаар сувилагч Г.Ариунтуяа, Д.Бүжинлхам нарын шагналын материалыг бүрдүүлж холбогдох газарт өгсөн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улаанбаатар хотын Сэргээн засах төв эмнэлэгт их эмч Э.Сайханжаргал, гуравдугаар төв эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт ахлах сувилагч Э.Сарангоо нар 10 хоногийн ажлын байрны сургалтад хамрагдаж, түнхний үе солих хагалгааны дараах дасгал хөдөлгөөн, Эрүүл мэндийн сайдын 814 дүгээр тушаалын дагуу үйлчлүүлэгчийг эрэмбэлэн ангилж сурсан.<br><br>Байгууллагын дотоод журмын дагуу 5 эмч, эмнэлгийн ажилчдад 7 хоногийн цалинтай чөлөө олгосон.<br>Байгууллагын ажилчдын хүүхдүүдэд зориулан төлөвлөгөөг 8 чиглэлээр гаргаж төлөвлөн Гэр бүл хөгжлийн газарт тайланг хугацаанд хүргүүлсэн.<br><br>Жил бүр уламжлал болгон хүүхдийн баяраар ажилчдын хүүхдүүдийг хүлээн авч тэмцээн, уралдаан зохион байгуулж тухайн жилдээ урлаг спорт, сурлагаар амжилт гаргасан хүүхдүүдийг урамшуулдаг зан үйлийг хэвшүүлсэн.<br>Нийт 29 хүүхдэд 495000 мянган төгрөгийн витминжуулалт хийсэн. | |
| 1.1.10 | | БӨХ | Иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор амбулаторийн өрөөг тохижуулна. | 50% | 70% | 5А, 8А дугаар өрөөнүүдыг амбулаторийн үзлэг оношлогоо, бариа заслын өрөө болгон тохижуулж 168 хүнд өдрийн эмчилгээ хийгдсэн байна. | |
| 1.1.11 | ЭМХТ-ийн 2022 оны 1152 албан бичгийн дагуу шинжээчийн | БӨХ | Байгууллагад хэрэглэх бичиг баримтанд товчлол үг бичих, ашиглах журам баталж хэрэгжүүлэн ажиллана. | 0 | 100% | Уламжлалт анагаах ухааны төвийн даргын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/06 дугаар тушаалаар “Байгууллагад хэрэглэх бичиг баримтанд товчлол үг бичих, ашиглах журам”-ыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | багийн зөвлөмж | | | | | баталсан. | |
| 1.1.12 | | БӨХ | Үйлчлүүлэгчээс гарсан оношилгоо эмчилгээний зардлын нөхөн төлбөрийг олгодог байх журмыг боловсруулан баталж хэрэгжүүлэн ажиллана. | 0 | 100% | Үйлчлүүлэгчээс гарсан оношилгоо эмчилгээний зардлын нөхөн төлбөрийг олгодог байх журмыг боловсруулан баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>Одоогоор үйлчлүүлэгчээс гарсан оношилгоо эмчилгээний зардал байхгүй 100% байгууллагаас гаргаж байгаа. | |
| **Дундаж хувь** | | | | | | | **100%** |
| **ХОЁР.ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ** | | | | | | | |
| **Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт:** 2.1 Төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй чанартай хүргэх | | | | | | | |
| 2.1.1 | Завхан аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл | БӨХ | Чанарын аян, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулна. /нийтийн эзэмшлийн зам талбайд биеэ зөв авч явах, явдал мөрийн талаар/ | 3 | 4 | “Таван цулын ач тус” сэдвээр нээлттэй хаалганы өдөрлөгийг 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр ЭМГ-ын хамт олон болон хэвтэн эмчлүүлэгчид, ажилчдын дунд зохион байгуулж, 10 гаруй нэр төрлийн хоолоор үйлчилсэн.<br><br>Эдгээр бүтээгдэхүүн нь хий ядаргаа тайлах, дархлаа дэмжих зорилгоор ашигладаг.Үүнд:<br><br>1.Гүзээнд хийсэн битүү шөл<br>2.Гүзээний ороомог, салат, шаржигнуур<br>3.Хонь болон үхрийн элгээр хучмал, нухаш, котлет, шаржигнуур<br><br>4.Уушгины бөөрөнцөг, хуушуур<br>5.Толгой шийрээр царцаамаг<br>6.Байцаа, лууван, хүрэн манжин гэх мэт<br><br>Мөн “Таван цулын ач тус” сэдвээр брошур гаргаж 40 гаруй хүнд тараасан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ба мэдээ мэдээллээр ханган ажилласан.<br><br>Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлгийн уламжлалтын тасаг, Отгонтэнгэр рашаан сувилал, Уламжлалт анагаах ухааны төв хамтран “Уламжлалт анагаах ухааны аргаар өвчнөөс урьдчилан сэргийлье” нээлттэй хаалганы өдөрлөгийг 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Гэр бүл, хүүхэд залуучуудын төвд зохион байгуулсан.<br><br>Уламжлалт анагаах ухааны төвийн дарга Д.Өлзийбаяр “Монголын уламжлалт анагаах ухааны талаар товч ойлголт” сэдвээр илтгэл тавьсан.<br><br>Уламжлалт анагаах ухааны аргаар өвчнөөс урьдчилан сэргийлье” нээлттэй хаалганы өдөрлөгийн үйл ажиллагаанд нийт 130 хүн хамрагдаж, үүнээс 75 үйлчлүүлэгч нь үзлэг оношилгоо хийгдэж, өдөрлөгт хамрагдсан үйлчлүүлэгчдэд “Уламжлалт анагаах ухааны өвчнөөс урьдчилан сэргийлэх ёс”, “Зөв зохистой хооллолт”, “Идээ ундаагаа хэрхэн зохицуулж хооллох”, “Өвчин болох ёс”, “Таван цулын ач тус”, “Уламжлалт эмчилгээний үед барих гам цээр”, “Монгол эмийн тухай ойлголт”, “Идээ ундаагаар өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх ёс”, “Хүний биед улирал хэрхэн нөлөөлдөг” зэрэг сэдвүүдээр брошур хийж 100 гаруй үйлчлүүлэгчид тараасан. Бумба 10, хэсэг газрын бариа 14 үйлчлүүлэгчид хийсэн. | |
| 2.1.2 | | БӨХ | Жинст багт байрлах сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд уламжлалт өв соёл, зан | 0 | 50 | Хүүхдүүдийг монгол ахуй соёл, өв уламжлалыг таниулах, хадгалах, хамгаалах, урлагын мэдрэмжийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | заншлын сургалтыг явуулах. | | | дээшлүүлж оролцоог нэмэгдүүлэх, эрүүл идэвхтэй хөдөлгөөнд уриалах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олныг нэгтгэхэд оршино.<br><br>Чанд-Эрдэнэ цогцолбор сургуулийн 11б ангийн 40 хүүхдэд “Идээ ундаа, явдал мөр”, “Эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэх, үнэлгээ өгөх” зэрэг сэдвүүдээр 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр сургалт явуулж 7 хоногийн аян зарлаж уралдаан тэмцээн зохион байгуулж шагнаж урамшуулсан. Үүнд:<br><br>➢ Баг тус бүрээс мэндчилгээг Зэрэг нэмэхийн өмнө, Хүргэн хүү, Энэ хүүхнүүд үү, Аман хуур, Сэрэлт киногоор 10 минутад багтаан жүжигчилсэн тоглолт<br>➢ Гоцлол дуу /ганцаарчилсан болон багаараа/<br>➢ Бүжиг /нийтийн болон ганцаарчилсан/ гэх мэт<br>➢ Сурагчдад “Хэрхэн зөв хооллох” талаар сургалт явуулж 5 цулаар 5 нэр төрлийн хоол хийх аргачлалыг зааж өгсөн. | |
| 2.1.3 | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/578 дугаар тушаал | БӨХ | Сэтгэл ханамжийг судалгааг сар бүр авч нэгтгэн тайлагнаж ажиллана. | 90 | 100 | ЭМС-ын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/578 тушаалын дагуу амбулаторийн 40 үйлчлүүлэгч, хэвтэн эмчлүүлсэн 125 үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгааг цаасаар болон QR-кодоор авч нэгтгэн тайланг гаргасан. Энэ талаар бүх ажилчдад сургалт явуулсан. | 100 |
| 2.1.5 | ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар | БӨХ | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт–шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тайлагнана. | | Төлөвлөгөөнд хяналт үнэлгээ | Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хэмжээнд 49 үйл ажиллагаа төлөвлөн ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тушаал | | | | хийгдсэн байна. | Дотоод хяналтын баг 2023 оны 03 дугаар сарын 24-ны өдөр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд графикт хуваарийн дагуу хяналт үнэлгээ хийж ажилласан.<br><br>Wings программ дээр шинэчлэл хийгдэх болгонд эмч нар сувилагч нарт программ дээр ажиллах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг тухай бүр нь тогтмол хийж хэвшсэн.<br><br>Яаралтай тусламжийн өрөө, эм эмнэлгийн хэрэгслэлийн бэлэн байдалд дотоод хяналтын багаас үнэлгээ хийхэд хэрэгжилт 90 хувь байсан. | |
| 2.1.6 | Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоол | БӨХ | Ажилчдын хувийн хэрэг, албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, мөрдөн ажиллана. | 18 | 22 | Ажилчдын хувийн хэрэг, албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, мөрдлөг болгон ажиллаж байна.<br><br>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал бүр гаргаж холбогдох газарт өгсөн. Үүнд:<br><br>➢ I улирлын үнэлгээ -94.7 хувь<br>➢ II улирлын үнэлгээ -90.3 хувь<br>➢ III улирлын үнэлгээ -94.3 хувь | 100 |
| 2.1.7 | Байгууллагын дотоод журам | БӨХ | “Амин дэм” битүү шөл, Элэг, сүүлтэй котлетыг байгууллагын брэнд хоол бий болгоно. | 0 | 50% | Ахлах тогооч А.Хажидмаа, тогооч Д.Баярмагнай нар амин дэм битүү шөл, элэг сүүлтэй котлетын технологи картыг шинэчлэн баталгаажуулж, хэвтэн эмчлүүлэгч болон өөрсдийн ажилчдад “Амин дэм” битүү шөлөөр 450 гаруй хүнд, Элэг сүүлтэй котлетоор 480 гаруй хүнд тус тус үйлчилж, үйлчлүүлэгчдийн сэтгэл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ханамжийн судалгаагаар сайн үнэлгээ авсан.<br><br>“Уламжлалт анагаах ухааны аргаар өвчнөөс урьдчилан сэргийлье” нээлттэй хаалганы өдөрлөгийг 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулж, үйлчлүүлэгчдэд үзлэг оношилгоо, үйлчилгээ үзүүлэхээс гадна элэгний хучмал, мини пирошки, стужин, гүзээний салат, пүнтүүз гүзээтэй салат, гүзээний шөл, аньс, чацарганы шүүсээр 130 гаруй хүнд үйлчилсэн.<br><br>Хоолны тендерийг зарлахаар бэлтгэл ажлыг хангэн ажиллаж байна. | |
| 2.1.8 | ЭМС-ын 2022 оны А/352 дугаар тушаал | БӨХ | Үйлчлүүлэгчийг унах бэртэх эрсдэлээс сэргийлсэн анхааруулга шаардлагатай цэгүүдэд байршуулж ажиллана. | 50% | 70% | Үйлчлүүлэгчийг унах бэртэх эрсдэлээс сэргийлсэн 2 самбар, үзүүлэх маягт, таних тэмдэглэгээ, анхааруулгыг шаардлагатай цэгүүдэд байршуулж ажиллаж байна.<br><br>Таних тэмдгийг 23 үйлчлүүлэгчдэд зүүж эрсдлээс сэргийлж ажилласан. | 100 |
| 2.1.9 | ЭМС-ын 2019 оны А/611 дүгээр тушаал | БӨХ | Тусламж үйлчилгээ авахаар ирсэн тохиолдол бүрт бүртгэл хөтөлж, авсан арга хэмжээний талаар тэмдэглэл хөтөлнө. | 70% | 80% | • Уламжлалт анагаах ухааны төвийн “Лавлагаа мэдээллийн хөтөч сувилагчийн ажиллах журам”-ыг даргын 2022 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>• Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, хүлээгдлийг бууруулах, үйлчлүүлэгчийг тосож | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчлэх, эмнэлгийн доторх урсгалыг зохицуулах, тусламж үйлчилгээний талаар мэдээллээр хангах болон хөтөч сувилагч лавлагаат үйлчилгээг үзүүлдэг.<br>• Хүлээгдлийн танхимд дуутай болон дуугүй хөтөч ажилладаг.<br>• Хөтөч сувилагч нь үйлчлүүлэгчийг хүлээн авч эрэлтэд нийцсэн үйлчилгээг авах нөхцөлийг бүрдүүлж, үйлчлүүлэгчийг угтан авах, чиглүүлэх, лавлагаа мэдээллээр хангах, хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настнуудыг тусламж үйлчилгээнд хамруулах болон хүлээлгийн танхимын зохион байгуулалтыг хариуцдаг. | |
| 2.1.10 | ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаал | БӨХ | Шинэ ажилтанг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан байна. | 0 | 100% | Шинээр ажилд орсон их эмч Э.Одгэрэл, дүн бүртгэгч Б.Ариунжаргал, сантехникч жолооч Г.Түвшинбаяр, сувилагч П.Ганбилэг нарыг аймгийн нэгдсэн эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт 14 үзүүлэлтээр үзүүлэн үр дүнг тооцон ажиллаж байна. | 100 |
| 2.1.11 | ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаал | БӨХ | Тусдаа угаалгын газартай, урсгал нь зөв байна. | 50% | 80% | Угаалгын газрын зураг байршлыг тодорхойлж 3.000.000 төгрөгний барилгын материал авч тохижуулсан. | |
| 2.1.12 | MNS5700:2020” стандарт, Монгол улсаас “Гамшгаас хамгаалах тухай” хууль | БӨХ | Гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, нөхөн сэргээх төлөвлөгөөтэй ажиллана. | 70% | 90% | Жил бүр “Гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ”-ний талаар нөхөн сэргээх төлөвлөгөө гаргаж тухай бүрт тодотгол хийн ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.13 | MNS5700:2020" стандарт | БӨХ | Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм заавартай, сургалт явуулдаг санамжийг холбогдох ажлын байран дээр байрлуулж, хяналт тавьж ажиллана. | 80% | 90% | Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм, заавартай, сургалт явуулдаг, санамжийг холбогдох ажлын байран дээр байрлуулж, хяналт тавин ажиллаж байна. | 100 |
| 2.1.14 | MNS5700:2020 стандарт, ЭМС-ын 2018 оны А/344 дүгээр тушаал | БӨХ | Тоног төхөөрөмжийг ашиглах ажиллуулах болон аюулгүй ажиллагааны сургалтыг хийж, техник ашиглалтын паспортыг тогтмол хөтөлнө. | 60% | 90% | Байгууллагын хэмжээнд мөрддөг галын аюулгүй ажиллагааны батлагдсан заавартай, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.<br><br>2023 оны 8 дугаар сарын 2-ны өдөр ажилтан М.Батчулуунаар "Физик эмчилгээний багаж тоног төхөөрмжийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа" сэдвээр ажилчдад сургалт зохион байгуулсан.<br><br>Мөн 2023 оны 7 дугаар сард ОБГазартай хамтран галын аюулгүй байдлын дадлага, сургалтыг зохион байгуулж ажилласан. | 100 |
| 2.1.15 | MNS5700:2020" стандарт, Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015" | БӨХ | Эм зүйн тусламж үйлчилгээнд мөрддөг дүрэм, журамтай, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | 20% | 50% | Эмнэлгийн эмийн санг стандартын дагуу зохион байгуулж монгол эм болон яаралтай тусламжийн европ эмээр ангилан ялгалт хийж байршуулсан.<br><br>Өндөр эрсдэлтэй болон ижил дуудагдах эмийг эмчилгээнд хэрэглэх, ангилан ялгах журмыг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/16 дугаар тушаалаар баталж, өндөр эрсдэлтэй эмийн жагсаалтыг гаргаж ил тодоор байршуулсан.<br><br>2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр европ эм эмнэлгийн хэрэгслэлийг 55 нэр төрлөөр, монгол эм танг 70 нэр төрлөөр тендерийг зарлаж 14-ны өдөр сонгон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгаруулалтыг явуулахаар товыг зарлан ажиллаж байна. | |
| 2.1.16 | ЭМС-ын 2019 оны 566 дугаар тушаал, ЭМС-ын 2020 оны А/625 тоот тушаал | БӨХ | Эм зүйн тусламжийн хүрээнд чанар аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг боловсруулж, дүн шинжилгээ хийнэ. | 2 | 4 | Эмийн чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг боловсруулан баталж мөрдлөг болгон ажиллаж байна.<br><br>Монгол эмийг хэрэглэх зааврын талаар нийт 145 хэвтэн эмчлүүлэгчдэд сургалт хийж гарын үсгээр баталгаажуулсан. | 100 |
| **Дундаж хувь** | | | | | | | **100%** |
| **Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** | | | | | | | |
| **Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт: 3.1** Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах | | | | | | | |
| 3.1.1 | МУАУ-ны НЭ-ийн стандарт MNS 5700:2020 | УТ | Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг өргөжүүлж батлагдсан орыг бүрэн ашиглана. | Орны фонд ашиглалт | Орны фонд ашиглалт | Үйлчлүүлэгчдэд уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтэн эмчлүүлэх тасаг гэсэн 2 чиглэлээр үзүүлж, эрүүл мэндийн газраас баталсан өдрийн 5 ор, хэвтүүлэн эмчлэх 35 ороор ажиллаж яаралтай тусламж, тусгаарлах өрөөг гарган 24 цагаар ажиллаж байна.<br><br>Эхний 10 сарын байдлаар өссөн дүнгээр эмчлүүлсэн хүний тоо 1390, ашигласан ор хоног 9731, дундаж ор хоног 6.9, орны фонд ашиглалт 278, орны эргэлт 40.2 байна. | 100 |
| 3.1.2 | Эрүүл мэндийн тухай хууль | БӨХ | Байгууллагын мэдээ мэдээллийн тайланг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх, мэдээний санд баяжилт хийнэ. | 12 | 12 | Тусламж үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагаанд мэдээллийн сангийн баяжилтыг тогтмол хийн статистик мэдээг 5 чиглэлээр сар бүр нэгтгэн ЭМГ-т мэдээлэсэн.<br><br>Мэдээ хоцроосон зөрүүлсэн зөрчил үгүй. Мэдээ өгсөн тоо-11<br><br>2023 оны мэдээг hinfostata мэдээллийн сангийн баазад шивж баяжилт хийсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сар бүрийн мэдээг мэдээллийн сангийн цахим программд шивж баталгаажуулсан. | |
| 3.1.3 | ЭМС-ын 2019 оны А/293-р тушаал | БӨХ | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулна. | 2 | 3 | Өглөө бүр ажилчдад эмчилгээ эхлэхээс 10 минутын өмнө эмчилгээний оношилгооны аппарат тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг шалгаж ХАБ хариуцсан ажилтан зааварчилгаа өгдөг. | 100 |
| 3.1.4 | Өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль | БӨХ | Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх мэдээ, тайланг хугацаанд нь хүргүүлнэ. | 85% | 88% | Төрийн үйлчилгээ, захидал, эрүүл мэндийн зөвлөгөө, санал хүсэлт, өргөдөл, гомдол, хүлээн авах цагийн хуваарь, ажилтны утасны дугаар, и-мейл хаяг зэргээр үйлчлүүлэгчдэд мэдээлэл өгөх журмын дагуу мэдээллийг хүргэн ажиллаж байна.<br>Байгууллагад ирсэн нийт өргөдлийн тоо –15<br>➢ Боловсон хүчинтэй холбоотой ажил хүссэн-10 өргөдөл<br>➢ Ажилчдын нийгмийн асуудалтай холбоотой-5 өргөдөл<br><br>Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайланг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/50 дугаар тушаалын 2-р хавсралт хүснэгтийн дагуу гарган ЗДТГ-ын хяналт-үнэлгээ, шинжилгээний хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. | 100 |
| **Дундаж хувь** | | | | | | | **100%** |
| **Дөрөв. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт**<br><br>**Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт 4.1 Байгууллагын дотоод хяналтыг сайжруулан, төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган өр авлагагүй ажиллаж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн үр ашигтай зарцуулан ажиллана.** | | | | | | | |
| 4.1.1 | МУАУ-ны НЭ-ийн стандарт MNS | БӨХ | Тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж шинээр шинжилгээний аппаратны тоог | | Гүйцэтгэл 100% | Тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж шинээр Автоклав улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1500000 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 5700:2020 | | нэмэгдүүлнэ. | | байна | төгрөг, утаат төөнүүрийн чихний аппарат, шээсний шинжилгээний аппарат, бумбаны ариутгалын аппарат, дээжний хөргөгчийг өөрийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан. | |
| 4.1.2 | ЭМ-ийн тухай хууль 20.2.7 | БӨХ | Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг төгсөлтийн дараах сургалт, багц цагийн цагийн сургалтад хамруулна. | 80% | 90% | Улаанбаатар хотын Сэргээн засах төв эмнэлэгт их эмч Э.Сайханжаргал, гуравдугаар төв эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт ахлах сувилагч Э.Сарангоо нар 10 хоногийн ажлын байрны сургалтад хамрагдаж, түнхний үе солих хагалгааны дараах дасгал хөдөлгөөн, Эрүүл мэндийн сайдын 814 дүгээр тушаалын дагуу үйлчлүүлэгчийг эрэмбэлэн ангилж сурсан.<br><br>Төрийн сангийн санхүүжилтаар УАУТХ-гийн эмнэлэгт их эмч Э.Мөнх-итгэл дотрын эмчээр мэргэжил дээшлүүлэх сургалтад, их эмч Д.Өлзийбаяр ӨМӨЗО-ны Олон Улсын Монгол эмнэлгийн хороотой хамтран Уламжлалт анагаах ухааны эмч нарын мэргэжил дээшлүүлэх эмнэл зүйн сургалтад хамрагдаж Чихрийн шижин өвчнийг монгол эм, эмнэлгээр эмчлэх, тархины хар судлын өвчнийг монгол эмнэлгээр засах, бие сэтгэл засал, монгол эмийн аюулгүй хэрэглээ зэрэг сэдвүүдээр сургалтыг авч ажлын байранд хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>Их эмч Э.Сайханжаргал Үе мөчний өвөрмөц эмчилгээ, Эрүүл мэндийн байгууллагын соёлд авилага, ёс зүйн асуудлийг хөндөх нь зэрэг сэдэвт сургалтад тус тус хамрагдаж мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улаанбаатар хотод “Багана нурууны өвчний үед уламжлалт эмчилгээний шинэлэг аргуудыг хэрэглэх зарчим” сэдэвт сургалтад их эмч Б.Мөнх-Итгэл хамрагдсан.<br><br>2023 онд 4 их эмч, 11 эмнэлгийн мэргэжилтнүүд УНТЭ, АШУҮИС, ЭМХТ, УАУТХ, ШНЭМ, Амьдралд суурилж суралцахуй, Эерэг өөрчлөлт сайн сайхны ану хүрээлэн зэрэг байгууллагуудаас зохион байгуулсан “Харилцааны ур чадвар, эрүүл мэндийн цогц үйлчилгээ”, “УАУ-ы эмнэлзүйн сургалт-2”, “Тархины үхэл тодорхойлох баг чадавхжуулах сургалт”, “Эрүүл мэндийн цогц үйлчилгээ”, “Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, стресс менежмент” зэрэг сэдэвт сургалтуудад амжилттай оролцож багц цагаа 100 хувь биелүүлсэн. | |
| 4.1.3 | | БӨХ | Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээг стандарт удирдамжийн дагуу багаар үзүүлдэг байх чадварт эмч,, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургана. | 20% | 50% | Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасгийн их эмч Г.Ганчимэгээр яаралтай тусламж үзүүлэх гардан үйлдлүүдээр ажлын байрны сургалтыг явуулж их эмчийн мэдвэл зохих чадвар дадлыг бий болгож чадваржуулсан.<br><br>6 сувилагчийг нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасгийн их эмч Г.Ганчимэгээр яаралтай тусламж үзүүлэх үед хэрхэн ажиллах талаар гардан үйлдлүүдийг эзэмшүүлэх ажлын байрны сургалтыг явуулж сувилагчийн мэдвэл зохих чадвар дадлыг бий болгож чадваржуулсан. | 100 |
| 4.1.4 | ЭМС АЗД-тай хамтран ажиллах | БӨХ | Байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, | өр авлага гаргаагү | Өглөггүй ажиллан а. | Төсвийн хөрөнгийг хуваарьт зүйл ангид нь зарцуулан сар бүр тайлан мэдээг гаргаж холбогдох газруудад тайлагнан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гэрээний 3.2.17 | | 6.4 болон 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон ажиллана. | й | | тооцоо нийлж ажилласан. | |
| 4.1.5 | ЭМС АЗД-тай хамтран ажиллах гэрээний 3.2.18 | БӨХ | Байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн жилийн тайланг Эрүүл мэндийн газраар нэгтгэн гаргуулж, аудит хийлгэн дараа оны 3 дугаар сарын 5-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулна. | зөрчилгүй санал дүгнэлт авсан | Аудитын санал дүгнэлт зөвлөмж байна | 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг төрийн аудитаар баталгаажуулан Эрүүл мэндийн газарт нэгтгэн тайлагнасан. | 100 |
| 4.1.6 | Төрийн албаны тухай хууль | БӨХ | ЗГ-ын тогтоол шийдвэр, холбогдох хуулийн заалтуудыг танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | 100% | 100% | Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 488, 489, 491 дүгээр тогтоолуудыг нийт ажилчдад 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр уншиж танилцуулсан. Мөн “Энэ жил эрүүл жиндээ” аяны удирдамжийг танилцуулсан.<br><br>Шинээр болон шинэчлэгдсэн тушаал шийдвэрүүдийг тухай бүрт нь ажилчдад танилцуулсан. | 100 |
| 4.1.7 | ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тушаал | БӨХ | Байгууллагын дотоод хяналт шинжилгээ, үнэлгээг график төлөвлөгөөний дагуу хийнэ. | 70% | 100% | Дотоод баг нь нэгдүгээр улиралд Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, Wings программ дээр хөтлөгдөж буй АШМБ-ийн хөтлөлтийн талаар хяналт үнэлгээ хийхэд стандартын шаардлага хангасан байна. | 100 |
| **Дундаж хувь** | | | | | | | **100** |
| **Тав.Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт** | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 5.1 Байгууллагын ил тод байдлыг хангаж ажиллана** | | | | | | | |
| 5.1.1 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын | БӨХ | Мэдээллийн ил тод байдал байдлыг хангаж цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар | 85 | 90 | Эрүүл мэндийн даатгал болон санхүүжилт, дүн бүртгэлийн талаарх мэдээ мэдээллийн ил тод, харагдахуйц байдлаар байршуулан ажилчид болон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тухай хуулийн 6-р зүйл | | байрлуулан тогтмол шинэчлэн ажиллана. | | | үйлчлүүлэгчдийг тогтмол мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.<br><br>Мэдээллийн ил тод байдлыг ханган цахим болон мэдээллийн самбарт байрлуулан тогтмол шинэчлэн ажилласан. | |
| 5.1.2 | Шилэн дансны тухай хуулийн 5, 6 дугаа зүйл<br><br>ЗГ-ын 2016 оны 29-р тогтоол | БӨХ | Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангана. | 95% | 96% | Санхүүгийн тайлан мэдээг хуулийн хугацаанд нь шилэн дансанд болон байгууллагын ил тодын самбарт байрлуулан ойлгомжтой байдлаар байрлуулан иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжоор ханган ажиллаж байна. | 100 |
| 5.1.3 | Төсвийн тухай хууль тогтоомж, Шилэн дансны тухай хууль | БӨХ | Байгууллагын үр ашиггүй зардлыг багасгаж, төсөвт өр үүсгэхгүй, төсвийг үр дүнтэй зарцуулж, ил тод нээлттэй байдлыг ханган, ОНХС, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан тайлагнана. | 90% | шилэн дансанд хугацаанд нь байршуулсан байна. | Жилийн санхүүжилт, төсөв бүрдүүлэлтэнд дүн шинжилгээ хийж аль болох үргүй муу зардал гаргахгүй байхыг хичээж төсвийн зүйл ангийг үр ашигтай зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.<br><br>Байгууллагын санхүүтэй холбоотой мэдээллийг шилэн дансанд хугацаанд нь бүрэн байршуулж хэвшсэн.<br>Төсвийн хөрөнгийг хуваарьт зүйл ангид нь зарцуулан сар бүр тайлан мэдээг гаргаж холбогдох газруудад тайлагнан тооцоо нийлж ажилласан.<br><br>Өөрийн орлого болох ор хоногийн 10%-ийн төлбөрийг төрийн санд төвлөрүүлж ямар нэг зөрчилгүй ажилласан. | 100 |
| **Дундаж хувь** | | | | | | | **100%** |
| **Зургаа.Нэмэлт ажил** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **(байгууллагын дотоод ажил)** | | | | | | | |
| 6.1.1 | ТАТХууль | БӨХ | Аймгийн Засаг дарга удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь хэрэгжүүлэн ажиллана. | 90% | Үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. | Аймгийн засаг дарга болон харъяа удирдлага, удирдах дээд шатны байгууллага, хэлтэс агентлагуудаас өгсөн үүрэг даалгавруудыг цаг тухай бүр нь гүйцэлдүүлж ажлын тайлан мэдээг хүргүүлсэн.<br><br>Аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Цасны баяр 2023” цасны баярын үйл ажиллагаанд хамт олноороо идэвхтэй оролцсон.Үүнд:<br>1.Уулын оргил булаалдах<br>2.Олс таталт<br>3.Сайхан хос морьтон шалгаруулах<br>4.Эрэгтэй, эмэгтэй буухиа тэмцээн<br>5.Флаш моб бүжиг<br>6.Нийтийн бүжиг<br>7.Хөл бөмбөг<br>Хөл бөмбөгөөр багаараа хоёрдугаар байранд орсон.<br>Дэлхийн эмч нарын баярт зориулсан гар бөмбөгийн тэмцээнд эмч нарын баг амжилттай оролцож 2 дугаар байр эзэлж мөнгөн медаль авсан.<br>Завхан аймгийн байгаль, аялал жуулчлалын газрын “Бүх нийтээр мод тарих тухай”, аймгийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн “Уламжлалт анагаах ухаанаар эрүүл мэндээ хамгаалья” сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах гэх мэт | 100 |
| 6.1.2 | Төрийн албаны тухай хууль, ЗГ-ын 2019 оны 33 | | Төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний албаны Ёс зүйн зөвлөлийг журмын дагуу байгуулж, төрийн албан | Зөрчилгүй | Ёс зүйн зөрчилгүй ажиллас | Ёс зүйн баг нь жилийн ажлын төлөвлөгөө батлуулж Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 дугаар тушаалын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дугаар тогтоол,<br><br>ЭМС-ын 2019 оны А/406 дугаар тушаал | БӨХ | хаагчийн ажиллуулах ёс зүйн хэм хэмжээг чанд сахина. | | ан байна. | хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>Нийт ажилчдад “Байгууллагын соёл, хөгжил” сэдэвт сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 24-ны өдөр зохион байгуулсан. Ёс зүйн баг нь эмч, эмнэлгийн ажилчдаас “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс дүрэм”, “Сувилахуйн мэргэжилтний ёс зүйн дүрэм” зэргээ тест боловсруулан шалгалт авч ажилласан.<br><br>Нийт ажилчдын дунд ёс зүйгээр “АХА” тэмцээн зохион байгуулж эхний байрыг шалгаруулж, ур чадварын нэмэгдэл 5 хувиар шагнаж урамшуулсан.<br><br>Ажилчдын ёс зүйтэй холбоотой санал гомдол ирээгүй болно. | |
| 6.1.3 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, ҮАБЗ-ийн 2021 оны 03 дугаар зөвлөмж | БӨХ | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажилд оролцоно. | | 15ш | Байгууллагын нийт ажилчид “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр шар хуас 13 ширхэг, хүрэн бургас 12 ширхэг, улиас 25 ширхэг, бургас 20 ширхэг, нийт 70 мод тарьж 286000 төгрөг зарцуулсан. | 100 |
| 6.1.4 | Хог хаягдлын тухай хууль, Аймгийн ИТХ-ын 2019 оны 56 тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны А/312 дугаар захирамж | БӨХ | Нийтийг хамарсан цэвэрлэгээний ажил, хариуцсан талбайн цас, мөсийг цэвэрлэхэд идэвхтэй оролцоно. | | 50 м хүртэл талбайд | Байгууллагын хариуцсан талбайн цас, мөсийг 2 үйлчлэгч ээлжлэн хуваарийн дагуу 8 удаа цэвэрлэж тайланг холбогдох газарт хүргүүлсэн.<br><br>Завхан аймгийн Улиастай сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 1/180 албан бичгийн дагуу Хаврын их цэвэрлэгээг 5 дугаар сарын 26-27 өдрүүдэд “Дээд постноос дээш | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | голын ай сав дагуу сайн яваарай самбар" хүртэл бүх ажилчид цэвэрлэж, цэвэрлэсэн хог хаягдлаа өөрийн байгууллагын авто машинаар ачиж нэгдсэн хогийн цэгт 10 шуудай хог буулгасан.<br><br>Мөн Улиастай сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 1/72 албан бичгийн дагуу өөрийн эзэмшил газрын хог хаягдлыг 14 хоног тутам цэвэрлэж тайланг saruul01234@gmail.com хаягаар тогтмол хүргэж ажилласан. | |
| **Завхан аймаг үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд бүтээлч ажил санаачлан зохион байгуулах, хэрэгжилтийг ханган ажиллана.** | | | | | | | |
| 6.5 | Төсвийн тухай хууль | БӨХ | Байгууллагын өнгө үзэмжийг сайжруулж шаардлагатай урсгал засварын ажлыг хийнэ.(эмнэлгийн гадна талд шохой замаск хийх, дээвэр солих гэх мэт) | Засвар хийгдсэн байна. | 60% | Байгууллагын өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн эмнэлгийн барилгад дараах засваруудыг хийж байна. Үүнд:<br><br>➢ Тамхины цэгийг шинээр байгуулсан.<br>➢ Гадна талд эмульс, шавар, будаг хийсэн.<br>➢ Үүдний хаалгыг төмөр хаалгаар шинэчлэн сольсон.<br>Нийт барилгын урсгал засварт 9,0 сая төгрөг зарцуулсан. | 100% |
| **Дундаж хувь** | | | | | | | **100** |
| **Гүйцэтгэлийн дундаж хувь:** | | | | | | | **100%** |